



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 1/24


Улаанбаатар хот

“Монгол бичигтэн НХОГ” аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын албан хаагчдын дунд “Монгол бичигтэн НХОГ” аяныг зохион байгуулж, хөтөлбөрийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Холбогдох зардлыг гарган олгохыг Санхүү, аж ахуйн хэлтэс /Ц.Алтангэрэл/-т зөвшөөрсүгэй.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтэс /Ш.Саранчимэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2021 оны 05 сарын 04-ны өдрийн 1/27 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



“Монгол бичигтэн НХОГ” аяны хөтөлбөр

Нэг. Хөтөлбөрийн зорилго

“Монгол бичиг үндэсний хөтөлбөр-III”-ын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг Кирилл болон Монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид байгууллагын ажилтан, албан хаагчдыг монгол бичигт шилжихэд Монгол бичгийн сургалт, судалгаа, хэрэглээний орчныг бүрдүүлж, бэлтгэлийг бүрэн хангахад оршино.

Хоёр. Хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийг 2021 оны 04 дүгээр сарын 30-наас 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хэрэгжүүлнэ.

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Байгууллагын нийт албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгаа авах.

3.2. Байгууллагын нийт албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшин тус бүрт тохирсон цуврал сургалтыг үе шаттайгаар явуулах

3.3. Нийт албан хаагчдыг дунд "Сайхан бичигтэн" Монгол бичгийн хуулан бичгийн уралдааныг зохион байгуулж, сайхан бичигтэн болон идэвхтэй хэлтсийг шалгаруулан урамшуулах ажлыг зохион байгуулах.

3.4. Мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын ажлын шугамаар ашигладаг дотоод сүлжээгээр Монгол бичиг сурах фото болон видео контентыг байршуулах

Дөрөв. Хүрэх үр дүн

Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулсан “Монгол бичигтэн-НХОГ” аяны хүрээнд:


-байгууллагын нийт албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон байна.

-Монгол бичгийн сургалт зохион байгуулснаар албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшин дээшилсэн байна.

-“Монгол бичиг үндэсний хөтөлбөр-III”-ын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг Кирилл болон Монгол бичгээр хөтлөн явуулахад байгууллагын албан хаагчдыг бэлтгэсэн байна.

115

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргын 2021 оны 05 сарын 04-ны өдрийн 1/24 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“Монгол бичигтэн НХОГ”

аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөө

№	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	Байгууллагын нийт албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгаа авах.	2021.04.28-30	ЗХХ-ийн мэргэжилтэн Б.Ундрахжаргал
2	Байгууллагын нийт албан хаагчдын Монгол бичгийн мэдлэгийн түвшин тус бүрт тохирсон цуврал сургалтыг үе шаттайгаар явуулах	Аяны хугацаанд	ЗХХ-ийн мэргэжилтэн Б.Ундрахжаргал
3	Нийт албан хаагчдыг дунд "Сайхан бичигтэн" Монгол бичгийн хуулан бичгийн уралдааныг зохион байгуулж, сайхан бичигтэн болон идэвхтэй хэлтсийг шалгаруулан урамшуулах ажлыг зохион байгуулах.	Аяны хугацаанд	ЗХХ-ийн мэргэжилтэн Б.Ариунтуяа
4	Мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран байгууллагын цахим хуудас болон албан хаагчдын ажлын шугамаар ашигладаг дотоод сүлжээгээр Монгол бичиг сурах фото болон видео контентыг байршуулах	Тогтмол	ЗХХ-ийн мэргэжилтэн Б.Ариунтуяа